

Тунхаглалын эцсийн хувилбар
2020 оны 01 дүгээр сар

УСНББОУС™

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт™

**Хамтын болон Хувийн Үйлчилгээ
(УСНББОУС 19, Нөөц, Болзошгүй Өр
Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө-ийн
Нэмэлт өөрчлөлт)**

IPSASB

Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™



**Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™**

Энэхүү баримт бичгийг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ™) боловруулж, баталсан.

УСНББОУСЗ-ийн зорилго нь улсын секторын нягтлан бодох бүртгэлийн өндөр чанартай стандартуудыг тогтоох, тэдгээрийн мөрдөлт ба хэрэгжүүлэлтэнд туслалцаа үзүүлэх, ингэснээр дэлхий дахины практикын чанар ба тууштай байдлыг сайжруулах, улсын секторын санхүүгийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх замаар олон нийтийн эрх ашигт үйлчлэх явдал юм.

Энэхүү зорилтыг биелүүлэхийн тулд УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагууд, үүн дотроо үндэсний, бүсийн, орон нутгийн засгийн газрууд болон засгийн газрын холбогдох агентлагууд ашиглахад зориулсан УСНББС™ ба Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ)-уудыг гаргадаг.

УСНББОУС нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (санхүүгийн тайлан)-д хамааралтай бөгөөд бүрэн эрхтэй байдаг. СБПУ-ууд нь санхүүгийн тайланг биш, харин нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан илтгэл (НЗСТИ)-ийг бэлтгэх сайн практикын талаархи заавар удирдамжаар хангадаг тунхаглалууд юм. УСНББОУС-аас ялгаатай нь, СБПУ нь шаардлагуудыг тогтоодоггүй. Санхүүгийн тайлан биш, харин НЗСТИ-тэй холбоотой бүх тунхаглалууд нь одоогоор СБПУ-ууд байна. СБПУ-ууд нь мэдээлэлд хамаарах баталгааны (хэрэв байгаа бол) түвшний талаархи заавар удирдамжаар хангадаггүй.

УСНББОУСЗ-ийн үйл ажиллагаагаа явуулах бүтэц болон үйл явцад Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо™ (ДНБХ™) дэмжлэг үзүүлдэг.

Зохиогчийн эрх © 2020 оны 01 дүгээр сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ). Зохиогчийн эрх, худалдааны тэмдэг, зөвшөөрлийн талаархи мэдээллийг [14-р хуудаснаас](#) үзнэ үү.

ХАМТЫН БОЛОН ХУВИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (УСНББОУС 19-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

АГУУЛГА

	Хуудас
УСНББОУС 19, <i>Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө</i> -ийн нэмэлт өөрчлөлт	4
УСНББОУС 42, <i>Нийгмийн Халамжийн Тэтгэмж</i> -ийн нэмэлт өөрчлөлт	13

Зорилго

1. УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийн зорилго нь хамтын болон хувийн үйлчилгээний хувьд нөөц үүсгэх эсэхийг тодорхойлох заавар удирдамжаар хангах явдал юм. УСНББОУС 19-ийн цар хүрээнд хамаарахгүй нийгмийн халамжийн өргөн хүрээтэй тайлбар тодорхойлолтонд эдгээр ажил гүйлгээг өмнө нь тусган оруулсан байж болох юм. УСНББОУС 42, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-ийг хэвлэн нийтэлсэний дараа, УСНББОУС3 нь нийгмийн халамжийн тэтгэмжийн арай явцуу тодорхойлолтыг батлан гаргасан бөгөөд үүнд хамтын болон хувийн үйлчилгээг оруулахгүй хассан. Иймээс УСНББОУС3 нь УСНББОУС 19-д нэмэлт өөрчлөлт оруулах замаар хамтын болон хувийн үйлчилгээний хувьд нөөц үүсгэх эсэх талаархи заавар удирдамж гаргахаар шийдвэрлэсэн.

Харгалзан үзсэн УСНББОУС

УСНББОУС	Өөрчлөлтийн товч тойм
УСНББОУС 19, <i>Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө</i>	Хамтын болон хувийн үйлчилгээний хувьд нөөц үүсгэх эсэхийг тодорхойлох заавар удирдамжаар хангах.
УСНББОУС 42, <i>Нийгмийн Халамжийн Тэтгэмж</i>	УСНББОУС 42-ын цар хүрээнд хамаарахгүй зарим ажил гүйлгээний хувьд УСНББОУС 19-ийн заавар удирдамжийг харгалзах талаархи дагалдах нэмэлт өөрчлөлт.

УСНББОУС 19, Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө-д оруулсан нэмэлт өөрчлөлт

6А ба 111Л параграфыг шинээр нэмж, 18-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Шинэ текстийн доогуур зурсан.

Хавсралт А-гийн Мөрдөх Заавар Удирдамж (МЗУ1-МЗУ20-р параграф), түүнчлэн Дүгнэлтийн Үндэслэлийн *Хамтын болон Хувийн Үйлчилгээ*-нд (УСНББОУС 19-ийн Нэмэлт өөрчлөлт) хамаарах хэсгийг (ДҮ6-ДҮ21-р параграф) шинээр нэмсэн. Эдгээр нь шинэ хэсгүүд учраас ямар нэг байдлаар зурж тэмдэглээгүй.

...

Цар хүрээ

...

6А. Энэ Стандарт нь хамтын болон хувийн үйлчилгээний хувьд нөөц үүсгэх эсэх, хэрэв үүсгэх бол хэзээ гэдгийг тодорхойлох заавар удирдамжаар хангана (МЗУ2-МЗУ20-р параграф).

...

Тодорхойлолт

18. **Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:**

Хамтын үйлчилгээ гэдэг нь нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь авч үзэх үүднээс улсын секторын байгууллагын зүгээс тухайн нийгмийн бүх гишүүдэд нэгэн зэрэг үзүүлдэг үйлчилгээ юм.

...

Хувийн үйлчилгээ гэдэг нь нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь авч үзэх үүднээс улсын секторын байгууллагын зүгээс хувь хүн ба/буюу айл өрхөд олгодог бараа, үзүүлдэг үйлчилгээ юм.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

111Л. 2020 оны 01 дүгээр сард гаргасан, *Хамтын болон Хувийн Үйлчилгээ* (УСНББОУС 19-ийн Нэмэлт өөрчлөлт)-ээр 6А, МЗУ1-МЗУ20-р параграфыг шинээр нэмж, 18-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 42, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-ийг мөн уг өмнөх тайлант хугацаанд дагаж мөрдөнө.

...

Мөрдөх заавар удирдамж

Энэ хавсралт нь УСНББОУС 19-ийн саллигүй бүрэлдэхүүн хэсэг юм.

Танилцуулга

МЗУ1. Энэ Хавсралт нь хамтын болон хувийн үйлчилгээний хувьд нөөц үүсгэх эсэхийг тодорхойлох заавар удирдамжаар хангана. Эдгээр ажил гүйлгээ нь УСНББОУС 42, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-д заасан, нийгмийн халамжийн тэтгэмжийн тодорхойлолтыг хангахгүй (ба иймээс уг Стандартын цар хүрээнд хамаарахгүй). Үйлчилгээг үзүүлэхийн өмнө тэдгээр ажил гүйлгээний хувьд нөөц хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэх асуудлыг энэхүү Хавсралтанд авч үзнэ.

Хамтын болон хувийн үйлчилгээ

Хамтын болон хувийн үйлчилгээний цар хүрээ

МЗУ2. Хамтын үйлчилгээ бол улсын секторын байгууллагын зүгээс тухайн нийгмийн бүх гишүүдэд нэгэн зэрэг үзүүлдэг бөгөөд нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь авч үзэх санаа зорилготой үйлчилгээ гэж энэ Стандартад тодорхойлсон. Хамтын үйлчилгээг нэг хувь хүнд үзүүлснээр бусад хүмүүсийн хүртэж болох үйлчилгээний хэмжээг бууруулдаггүй; хамтын үйлчилгээний хэрэглээ ашиглалтанд атаархал өрсөлдөөн байдаггүй. Хамтын үйлчилгээний хэрэглээ нь ихэвчлэн идэвхигүй байдаг бөгөөд нарийн дэлгэрэнгүй гэрээ хэлцэл эсвэл үйлчилгээг хүртэж буй хүмүүсийн идэвхитэй оролцоог шаарддаггүй.

МЗУ3. Хувийн үйлчилгээ бол улсын секторын байгууллагын зүгээс хувь хүн ба/буюу айл өрхөд олгодог бараа, үзүүлдэг үйлчилгээ бөгөөд нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь авч үзэх санаа зорилготой байдаг гэж энэ Стандартад тодорхойлсон. Хувийн үйлчилгээг нэг хувь хүнд үзүүлснээр бусад хүмүүсийн хүртэж болох үйлчилгээний хэмжээг бууруулж, эсвэл тэрхүү үйлчилгээг зарим хүмүүс хүлээн авах хугацааг хойшлуулж болох юм. Хувийн үйлчилгээний хэрэглээ нь нарийн дэлгэрэнгүй гэрээ хэлцэл эсвэл үйлчилгээг хүртэж буй хүмүүсийн идэвхитэй оролцоог шаарддаг. Улсын секторын байгууллагын зүгээс арилжааны нөхцлөөр нийлүүлж буй бараа, үйлчилгээ нь нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь авч үздэггүй, иймээс хувийн үйлчилгээний тодорхойлолтыг хангахгүй юм.

МЗУ4. Нийгмийн халамжийн тэтгэмж, хамтын болон хувийн үйлчилгээ нь бүгдээрээ нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь авч үздэг. Нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь авч үзэхдээ, хамтын буюу хувийн үйлчилгээ нэг бүрд тухайн нийгмийн бүх гишүүдийг хамруулсан байхыг шаардахгүй юм; ийм үйлчилгээ нь нийгмийн янз бүрийн сегментүүдийг хамардаг байж болно. Ижил төсөөтэй үйлчилгээний өргөн хүрээтэй системийн нэг хэсэг байдлаар нийгмийн сегментийг хамардаг хамтын буюу хувийн үйлчилгээ нь нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь авч үзэх уг шаардлагыг хангадаг.

МЗУ5. Хамтын болон хувийн үйлчилгээ нь улсын секторын байгууллагын үзүүлэх эсвэл түүний нэрийн өмнөөс үзүүлэх үйлчилгээг илэрхийлдэг. Иймээс мөнгөн шилжүүлэг нь хамтын эсвэл хувийн үйлчилгээ биш юм.

МЗУ6. Улсын секторын байгууллагууд нь өөрсдийн ажилчдаар дамжуулан эсвэл гуравдагч талын нийлүүлэгчдээс бараа, үйлчилгээг худалдан авснаар хамтын болон хувийн үйлчилгээг үзүүлдэг.

МЗУ7. Хамтын үйлчилгээний жишээнд батлан хамгаалах ажиллагаа, гудамжны гэрэлтүүлэг хамаарна. Хувийн үйлчилгээнд үнэгүй эсвэл нэрлэсэн өртгөөр үзүүлэх эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээ хамаарна. Хувийн үйлчилгээ нь тодорхой насанд хүрэх эсвэл оршин суух шаардлага гэх мэт зохих шалгууртай эсвэл шалгуургүй байж болно; гэвч зохих шалгуурын оршин байдал (буюу өөр бусад байдал) нь хувийн үйлчилгээний тодорхойлолтыг тухайн ажил гүйлгээ хангаж буй эсэхийг тогтооход нөлөөлөхгүй.

ХАМТЫН БОЛОН ХУВИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (УСНББОУС 19-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

- МЗУ8.** Хамтын үйлчилгээг хувь хүнд биш, харин нийгэмд үзүүлдэг, үүгээрээ хувийн үйлчилгээ болон нийгмийн халамжийн тэтгэмжээс ялгаатай байдаг. Хувийн үйлчилгээ нь хувь хүн ба/буюу айл өрхөд үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой бөгөөд мөнгөн шилжүүлэг (үүн дотроо, урьдчилж төлсөн дебит карт гэх мэт мөнгөтэй адилтгах хөрөнгө) олгодог нийгмийн халамжийн тэтгэмжээс ялгаатай юм.
- МЗУ9.** Зарим улс оронд хувь хүмүүс нь тухайлбал, эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг өөрөө төлж, дараа нь, улсын секторын байгууллага нөхөн олгодог байж болох юм. Энэхүү нөхөн төлбөр нь уг үйлчилгээний төлбөрийг тухайн улсын секторын байгууллага төлж буйтай адил мөн чанартай бөгөөд тэрхүү ажил гүйлгээ нь нийгмийн халамжийн тэтгэмж биш, харин хувийн үйлчилгээ болно.
- МЗУ10.** Нийгмийн халамжийн тэтгэмж (УСНББОУС 42-т тодорхойлсон), хувийн үйлчилгээ, хамтын үйлчилгээний гол шинж чанаруудыг дараах хүснэгтэнд зэрэгцүүлэн харуулав.

	Нийгмийн халамжийн тэтгэмж	Хувийн үйлчилгээ	Хамтын үйлчилгээ
Шалгуур хангасан тэтгэмж авагчид мөнгөн шилжүүлэг олгодог уу?	√	х	х
Нийгэмд биш хувь хүн ба/буюу өрхөд олгодог уу?	√	√	х
Нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь авч үзэх санаа зорилготой байдаг уу?	√	√	√

Үйлчилгээг үзүүлэхээс өмнө, хамтын үйлчилгээний хувьд нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй

- МЗУ11.** Хамтын үйлчилгээ үзүүлэх санаа зорилго, тийм үйлчилгээ үзүүлэх төсөв батлалт, эсвэл тэдгээр үйлчилгээний талаархи хууль тогтоомжийн оршин байдал нь одоогийн үүрэг үүсгэхэд дангаараа хангалтгүй байдаг.
- МЗУ12.** Хамтын үйлчилгээ нь тухайн үйлчилгээг үзүүлдэг улсын секторын байгууллагын байнгын тасралтгүй үйл ажиллагаа юм. Энэ Стандартын 26-р параграфт “байгууллагын ирээдүйн тасралтгүй үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулахын тулд гаргах шаардлагатай өртөг зардлын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй” гэж заасан. Иймээс энэ Стандартын зарчмын дагуу, ийм үйлчилгээ үзүүлэх санаа зорилгын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй.
- МЗУ13.** Хамтын үйлчилгээг үзүүлэхийн тулд улсын секторын байгууллагад хөрөнгө нөөц шаардлагатай бөгөөд тухайн байгууллага нь ихэвчлэн гэрээ болон бусад заавал биелүүлэх хэлцлийн дагуу зардал гаргаж байдаг. Жишээлбэл; гудамжны гэрэлтүүлэгт ашиглах цахилгаан, батлан хамгаалах ажилтнуудын үйлчилгээг худалдан авахад төлөх цалин хөлс, тэдгээр үйлчилгээг үзүүлэхэд ашиглах эргэлтийн бус хөрөнгийн олж эзэмшилт, гуравдагч талын нийлүүлэгчээс хамтын үйлчилгээг худалдан авалт. Эдгээр гэрээ буюу бусад заавал биелүүлэх хэлцлийг бусад УСНББОУС-ын дагуу тайлагнадаг. Зарим нөхцөл байдалд тухайлбал, гэрээ буюу бусад заавал биелүүлэх хэлцэл нь алдаатай болсон тохиолдолд тэдгээр нь нөөц үүсгэхэд хүргэж болох юм. Гэвч ийм аливаа нөөц нь хамтын үйлчилгээг олон нийтэд хүргэх санаа зорилготой биш, харин тухайн заавал биелүүлэх хэлцэлтэй холбоотой байдаг.

Үйлчилгээг үзүүлэхээс өмнө, хувийн үйлчилгээний хувьд нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй

- МЗУ14.** Хувийн үйлчилгээ үзүүлэх санаа зорилго, тийм үйлчилгээ үзүүлэх төсөв батлалт, эсвэл тэдгээр үйлчилгээний талаархи хууль тогтоомжийн оршин байдал нь одоогийн үүрэг үүсгэхэд дангаараа хангалтгүй байдаг. Хамтын буюу хувийн үйлчилгээний хувьд өр төлбөр үүсэхэд хүргэх өнгөрсөн үйл явдал байдаггүй. МЗУ7-р параграфт тэмдэглэсэнчлэн, хувийн үйлчилгээ нь тодорхой насанд хүрэх эсвэл оршин суух шаардлага гэх мэт зохих шалгууртай эсвэл шалгуургүй байж болно. Гэвч зохих шалгуурын оршин байдал (буюу өөр бусад байдал) нь хувийн үйлчилгээний тодорхойлолтыг тухайн ажил гүйлгээ хангаж буй эсхийг тогтооход нөлөөлөхгүй юм.

ХАМТЫН БОЛОН ХУВИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (УСНББОУС 19-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

- МЗУ15. Хувийн үйлчилгээ нь тухайн үйлчилгээг үзүүлдэг улсын секторын байгууллагын байнгын тасралтгүй үйл ажиллагаа юм. Хувийн үйлчилгээ үзүүлэхийн тулд улсын секторын байгууллагад хөрөнгө нөөц шаардлагатай бөгөөд тухайн байгууллага нь ихэвчлэн гэрээ болон бусад заавал биелүүлэх хэлцлийн дагуу зардал гаргаж байдаг.
- МЗУ16. Улсын секторын байгууллага нь тодорхой нэг хувь хүн ба/буюу өрхөд үйлчилгээ үзүүлэхийн тулд эдгээр нөөцийг ашигладаг. Хувь хүмүүс ба/буюу айл өрхүүд нь хувийн үйлчилгээнүүдэд хандан нэвтэрч ашигладаг тохиолдолд тухайн байгууллага нь тэдгээр хувийн үйлчилгээнүүдийг үзүүлэхтэй холбоотойгоор ирээдүйн олон тооны үүрэгтэй байж болох юм. Ийм үүрэг нь тухайн улсын секторын байгууллагын байнгын тасралтгүй үйл ажиллагааны шинж төлөв юм. Хувь хүмүүс ба/буюу айл өрхүүд нь тухайн үйлчилгээнд хандан нэвтэрч ашиглахаас өмнө, ийм үйлчилгээ үзүүлэх санаа зорилгын хувьд хамтын үйлчилгээтэй адилаар энэ Стандартын зарчмуудын дагуу нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй.
- МЗУ17. Хувийн үйлчилгээг үзүүлэхийн тулд олж эзэмших хөрөнгө нөөц ба гаргах зардлын жишээнд дараах зүйлс хамаарна. Үүнд: эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд ашиглах эм буюу эмнэлгийн хэрэгсэл, багш нарын үйлчилгээг худалдан авахад төлөх цалин хөлс, тэдгээр үйлчилгээг үзүүлэхэд ашиглах эргэлтийн бус хөрөнгийн (жишээлбэл; эмнэлэг, түргэн тусламжийн машин) олж эзэмшилт, гуравдагч талын нийлүүлэгчээс хувийн үйлчилгээг худалдан авалт. Эдгээр гэрээ болон бусад заавал биелүүлэх хэлцлийг бусад УСНББОУС-ын дагуу тайлагнадаг. Зарим нөхцөл байдалд тухайлбал, гэрээ буюу бусад заавал биелүүлэх хэлцэл нь алдаатай болсон тохиолдолд тэдгээр нь нөөц үүсгэхэд хүргэж болох юм. Гэвч ийм аливаа нөөц нь хувийн үйлчилгээг олон нийтэд хүргэх санаа зорилготой биш, харин тухайн заавал биелүүлэх хэлцэлтэй холбоотой байдаг.

Хамтын болон хувийн үйлчилгээний толилуулга ба тодруулга

- МЗУ18. Байгууллага нь хамтын болон хувийн үйлчилгээний талаархи мэдээллийг бусад УСНББОУС-ын, үүн дотроо УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*, УСНББОУС 2, *Мөнгөн Гүйлгээний Тайлан*, УСНББОУС 18, *Сегментийн Тайлагнал*-ын дагуу толилуулж, тодруулга хийнэ.
- МЗУ19. “Аль нь үнэн зөв илэрхийлэлт ба илүү хамааралтай мэдээллээр хангадаг эсэхээс шалтгаалан зардлын шинж төрөлд эсвэл тухайн байгууллагын хүрэн дэх зардлын чиг үүрэгт үндэслэсэн ангиллыг ашигласнаар уг байгууллага нь зардлын задаргаа шинжилгээг санхүүгийн үр дүнгийн тайланд эсвэл тодруулгад толилуулах”-ыг УСНББОУС 1-ээр шаардсан байдаг.
- МЗУ20. Байгууллага нь зардлын шинж төрөлд үндэслэн мэдээллийг толилуулдаг тохиолдолд хамтын болон хувийн үйлчилгээг ажилтны тэтгэмжийн зардал гэх мэт мөрийн зүйлсэд тусган оруулна. Харин тухайн байгууллагын хүрэн дэх зардлын чиг үүрэгт үндэслэн мэдээллийг толилуулдаг тохиолдолд байгууллага нь хамтын болон хувийн үйлчилгээг бие даасан мөрийн зүйлс байдлаар толилуулах буюу тэдгээрийн материаллаг байдлаас хамааран ижил төсөөтэй зүйлсийг нийлүүлж болох юм.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 19-ийг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Хамтын болон Хувийн Үйлчилгээ (УСНББОУС 19-ийн Нэмэлт өөрчлөлт)-ний үр дүнд УСНББОУС 19-д хийсэн хянан засварлалт

Хамтын болон Хувийн Үйлчилгээ

ДҮ6. УСНББОУС 19-ийг анх гаргах үед “нийлүүлсэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг тэдгээр үр өгөөж хүртэгчдээс хариу болгон шууд хүлээн авдаггүй байгууллагын үзүүлсэн нийгмийн халамжаас үүсэх нөөц ба болзошгүй өр төлбөр”-ийг уг Стандартын цар хүрээнд хамруулдаггүй байсан. “Нийгмийн халамж гэдэг нь засгийн газрын нийгмийн бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх явцад нийлүүлсэн бараа, үйлчилгээ болон бусад үр өгөөжийг хэлнэ. Ийм халамжинд дараах зүйлс хамаарч болно:

- (а) Тухайн нийгэмд эрүүл мэнд, боловсрол, орон байр, тээврийн болон бусад нийгмийн үйлчилгээ үзүүлэх. Ихэнх тохиолдолд энэ нь тэдгээр үйлчилгээний үнэ цэнэтэй адилтгах дүн төлөхийг уг үйлчилгээ хүлээн авагчдаас шаарддаггүй; ба
- (б) Гэр бүл, өндөр настан, тахир дутуу иргэд, ажилгүйчүүд, ахмад дайчид болон бусад иргэдэд олгосон тэтгэмжийн төлбөр. Өөрөөр хэлбэл, бүх түвшний засаг захиргааны байгууллага нь тухайн нийгмийн иргэд болон тодорхой бүлэг хүмүүст санхүүгийн туслалцаа үзүүлж, тэднийг өөрсдийн тухайлсан хэрэгцээ шаардлагаа хангах буюу орлогоо нэмэгдүүлэхийн тулд үйлчилгээ авах боломжийг олгодог” гэж УСНББОУС 19 нь нийгмийн халамжийг өргөн утгаар тодорхойлдог байсан.

ДҮ7. УСНББОУС 42, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-ийг 2019 оны 01-р сард гаргасан. УСНББОУС 42-оор УСНББОУС 19-д нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд одоо УСНББОУС 42-ын цар хүрээнд хамаарах нийгмийн халамжийн тэтгэмжийг (өөрөөр хэлбэл, нийгмийн халамж гэж өмнө нь нэрлэж байсан өргөн хүрээтэй ажил гүйлгээг биш, харин нийгмийн эрсдлийн үр нөлөөг бууруулахын тулд олгодог мөнгөн шилжүүлгийг (үүн дотроо, мөнгөтэй адилтгах хөрөнгийг)) УСНББОУС 19 нь өөрийн цар хүрээнээс хассан. УСНББОУС 19-ийн цар хүрээнээс өмнө нь хассан боловч УСНББОУС 42-ын цар хүрээнд хамруулаагүй тийм ажил гүйлгээнээс үүсэх аливаа нөөц болон болзошгүй өр төлбөрийг энэхүү нэмэлт өөрчлөлтийн үр дүнд УСНББОУС 19-ийн цар хүрээнд буцаан оруулсан. Иймээс УСНББОУС3 нь эдгээр ажил гүйлгээний тайлагналын талаархи заавар удирдамжаар хангахыг зөвшөөрсөн. УСНББОУС 19-д өмнө нь дурдсанчлан, оролцогч талуудын хувьд гол асуудал нь тэдгээр ажил гүйлгээтэй холбоотойгоор нөөц үүсэх эсэх явдал юм.

ДҮ8. Ийм ажил гүйлгээг УСНББОУС3-ийн Зөвлөлдөх Баримт Бичиг (ЗББ), *Орлого ба Арилжааны Бус Зардлын Тайлагнал*-д (2017 оны 8-р сард гаргасан) “хамтын үйлчилгээ”, “нийтлэг үзүүлж болох үйлчилгээ” гэж нэрлэсэн. (ДҮ10-р параграфт тайлбарласанчлан, УСНББОУС3 нь “нийтлэг үзүүлж болох үйлчилгээ” нэр томъёог дараа нь, “хувийн үйлчилгээ” нэр томъёогоор сольж орлуулахаар шийдвэрлэсэн.) “Нийтлэг үзүүлж болох үйлчилгээ болон хамтын үйлчилгээтэй холбоотой арилжааны бус ажил гүйлгээ нь тухайн хөрөнгө нөөцийн хүлээн авагчид гүйцэтгэлийн үүрэг хүлээлгэхгүй” гэсэн анхдагч байр суурийг УСНББОУС3 нь энэхүү ЗББ-т илэрхийлсэн. Иймээс эдгээр ажил гүйлгээний хувьд арилжааны бус зардлыг хүлээн зөвшөөрөх гүйцэтгэлийн үүргийн хандлага нь тохиромжгүй юм. ЗББ-т хариу ирүүлсэн хүмүүс нь уг анхдагч байр суурийг ерөнхийдөө дэмжсэн.

ДҮ9. “Улсын секторын байгууллага нь нийтлэг үзүүлж болох үйлчилгээ болон хамтын үйлчилгээг үзүүлэхтэй холбоотойгоор ирээдүйд олон үүрэг хүлээж болох юм. Ийм үүрэг нь засгийн газрын болон бусад улсын секторын байгууллагуудын байнгын тасралтгүй үйл ажиллагааны шинж төлөв юм; гэвч зөвхөн одоогийн үүрэг нь өр төлбөр үүсэхэд хүргэдэг. Хөрөнгө нөөцийн хүлээгдэж буй ирээдүйн зарцуулалт нь одоогийн үүрэг оршин байна гэсэн утгыг дангаараа илэрхийлэхгүй. Иймээс

ХАМТЫН БОЛОН ХУВИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (УСНББОУС 19-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

нийтлэг үзүүлж болох үйлчилгээ болон хамтын үйлчилгээ нь үүрэг хүлээлгэх үйл явдал болохгүй бөгөөд хүлээн авагчдад тэдгээр үйлчилгээг үзүүлэхээс өмнө өр төлбөр эсвэл зардал үүсэхгүй гэж УСНББОУСЗ үзсэн” гэдгээ УСНББОУСЗ нь ЗББ-т цохон тэмдэглэсэн.

- ДҮ10. ЗББ-т хариулт ирүүлсэн хүмүүс нь энэхүү байр суурийг мөн ерөнхийдөө дэмжсэн бөгөөд УСНББОУСЗ нь ЗББ-т заасан хандлагад нийцүүлэн эдгээр ажил гүйлгээг тайлагнах талаархи Мөрдөх Заавар Удирдамжаар хангахыг зөвшөөрсөн. Хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь “нийтлэг үзүүлж болох үйлчилгээ” нэр томъёо төөрөгдөлд хүргэж байна гэж үзэж буйг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн. УСНББОУСЗ нь энэхүү нэр томъёоноос татгалзаж, үүний оронд “хувийн үйлчилгээ” нэр томъёо ашиглахыг зөвшөөрсөн. Энэ нь Засгийн Газрын Санхүүгийн Статистик (ЗГСС)-т ашигласан нэр томъёо, түүнчлэн нийгмийн халамжийн тэтгэмжийн талаархи УСНББОУСЗ-ийн өмнөх хэвлэл бүтээлд ашигласан нэр томъёотой нийцэх юм.
- ДҮ11. Тэтгэмж авагчдад хамтын болон хувийн үйлчилгээг үзүүлэхээс өмнө тухайн үйлчилгээний нийлүүлэлтийн хувьд өр төлбөр буюу зардал үүсэхгүй учраас эдгээр үйлчилгээний нийлүүлэлтийг бусад УСНББОУС-ын дагуу тайлагнах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Жишээлбэл; УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж* нь эдгээр үйлчилгээг үзүүлэх ажилтныг хөлслөн ажиллуулахад гарах зардлыг, УСНББОУС 12, *Бараа Материал* нь хувь хүн ба айл өрхөд бараа нийлүүлэхэд гарах өртөг зардлыг, УСНББОУС 41, *Санхүүгийн Хэрэглүүр* нь бараа, үйлчилгээг олж эзэмшихэд гарч болох санхүүгийн өр төлбөрийг харгалзан зохицуулдаг.
- ДҮ12. Тэтгэмж авагчдад хамтын болон хувийн үйлчилгээг үзүүлэхээс өмнө тухайн үйлчилгээний нийлүүлэлтийн хувьд өр төлбөр буюу зардал үүсэхгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх үедээ УСНББОУСЗ нь хэдийгээр хамтын ба хувийн үйлчилгээний шинж төрөл ялгаатай боловч эдгээр зардлын хоёр ангиллын аль алины хувьд нөөцийг урьдчилан үүсгэхгүй байгаа шалтгаан үндэслэл ижил төсөөтэй гэж мэдэгдсэн. Уг заавар удирдамжид үүнийг тусгах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн
- ДҮ13. Хамтын үйлчилгээ нь засгийн газрын байнгын тасралтгүй үйл ажиллагаа гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. УСНББОУС 19-ийн 26-р параграфт “байгууллагын ирээдүйн тасралтгүй үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулахын тулд гаргах шаардлагатай өртөг зардлын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй” гэж заасан. Иймээс хамтын үйлчилгээний хувьд нөөц хүлээн зөвшөөрөх нь УСНББОУС 19-ийн 26-р параграфын шаардлагуудтай зөрчилдөнө гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ14. Хамтын үйлчилгээтэй адилаар хувийн үйлчилгээ нь засгийн газрын байнгын тасралтгүй үйл ажиллагаа бөгөөд ийм үйлчилгээний хувьд нөөц хүлээн зөвшөөрөх нь УСНББОУС 19-ийн 26-р параграфын шаардлагуудтай бас зөрчилдөнө гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн.
- ДҮ15. Хамтын болон хувийн үйлчилгээний хувьд тусгай тодруулга шаардлагатай эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн бөгөөд УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*, УСНББОУС 2, *Мөнгөн Гүйлгээний Тайлан*, УСНББОУС 18, *Сегментийн Тайлагнал*, түүнчлэн тодорхой ажил гүйлгээнүүдийг зохицуулдаг янз бүрийн УСНББОУС-ын одоогийн шаардлагууд нь хэрэглэгчдийн хэрэгцээг ханган биелүүлэхийн тулд хангалттай мэдээллийг бүрдүүлдэг гэж дүгнэсэн. Иймээс УСНББОУСЗ нь хамтын болон хувийн үйлчилгээний хувьд ямар нэг тусгай тодруулга шаардахгүй байхыг зөвшөөрсөн.
- СТ 67, *Хамтын болон Хувийн Үйлчилгээ ба Яаралтай Тусламж* (УСНББОУС 19-ийн Нэмэлт өөрчлөлт)-д ирүүлсэн хариултууд
- ДҮ16. 2019 оны 01 дүгээр сард УСНББОУСЗ нь СТ 67, *Хамтын болон Хувийн Үйлчилгээ ба Яаралтай Тусламж* (УСНББОУС 19-ийн Нэмэлт өөрчлөлт)-г гаргаж, өөрийн саналуудыг танилцуулсан.
- ДҮ17. Хариулт ирүүлсэн хүмүүс нь хамтын болон хувийн үйлчилгээний талаархи саналуудыг ерөнхийдөө дэмжсэн боловч уг нэмэлт өөрчлөлтүүдийг эцэслэн дуусгахдаа УСНББОУСЗ харгалзан үзэх шаардлагатай олон асуудлуудыг дэвшүүлэн тавьсан.

ХАМТЫН БОЛОН ХУВИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (УСНББОУС 19-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

ДҮ18. Эдгээр олон асуудлууд нь хамтын болон хувийн үйлчилгээний тодорхойлолтуудтай холбоотой байдаг. УСНББОУСЗ нь дараах учир шалтгааны улмаас уг тодорхойлолтуудад ямар нэг өөрчлөлт оруулахгүй байхаар шийдвэрлэсэн:

- (а) Нягтлан бодох бүртгэлийн арга хандлага нь ижил тохиолдолд хоёр өөр тодорхойлолт байх шаардлагатай эсэхэд эргэлзэж буйгаа хариулт ирүүлсэн зарим хүмүүс илэрхийлсэн. Хувийн үйлчилгээний шинж төрлөөс хамтын үйлчилгээний шинж төрөл өөр байгаа нь тусдаа тодорхойлолт зохистой гэдгийг илэрхийлж байна гэж УСНББОУСЗ үзсэн. Энэ нь ЗГСС-ийн хандлагатай нийцнэ гэдгийг УСНББОУСЗ мөн цохон тэмдэглэсэн.
- (б) Хамтын болон хувийн үйлчилгээнүүд нь мөнгөн бус ажил гүйлгээ бөгөөд тэдгээр тодорхойлолтонд үүнийг тусган оруулах хэрэгтэй гэж хариулт ирүүлсэн хүмүүс үзэж байсан. УСНББОУСЗ нь хамтын болон хувийн үйлчилгээний мөнгөн бус шинж төрлийн талаархи тодорхой заалтыг Мөрдөх Заавар Удирдамжид оруулахаар шийдвэрлэсэн.
- (в) Хувийн үйлчилгээний тодорхойлолтоос ялгаатай нь, хамтын үйлчилгээний тодорхойлолтонд яагаад барааг оруулаагүй талаар эргэлзэж буйгаа хариулт ирүүлсэн зарим хүмүүс илэрхийлсэн. Хамтын үйлчилгээг үзүүлэхэд ашигладаг барааг (гэрлийн чийдэнгийн тогтоогч гэх мэт) ЗГСС-т хамтын бараа гэж нэрлэдэг болохыг УСНББОУСЗ дурдан тэмдэглэсэн. Гэхдээ ийм хөрөнгө нь тухайн байгууллагын хяналтанд хэвээр үлдэх бөгөөд үйлчилгээ үзүүлэгчид түүнийг шилжүүлэн өгөхгүй. Иймээс УСНББОУСЗ нь хамтын үйлчилгээний тодорхойлолтонд барааг оруулахгүй байхыг зөвшөөрсөн.
- (г) Хариулт ирүүлсэн нэг хүн нь үйлчилгээг тасралтгүй үзүүлдэг гэдгийг илэрхийлэхийн тулд хамтын болон хувийн үйлчилгээний тодорхойлолтуудад нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргасан. Хамтын болон хувийн үйлчилгээ нь улсын секторын байгууллагуудын байнгын тасралтгүй ажиллагаа гэдгийг тэдгээрийн тайлбар тодорхойлолтод угаасаа шууд бусаар илэрхийлсэн бөгөөд эдгээр тодорхойлолтуудад өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж УСНББОУСЗ үзсэн. Одоогийн үүрэг үүсэхэд хүргэх өнгөрсөн үйл явдал нь тэрхүү үүргийн шалгуурыг хангах тухайн үйлчилгээ үзүүлэх үйл явцтай нэгэн зэрэг гарч тохиолддог тул хамтын болон хувийн үйлчилгээг байнга тасралтгүй үзүүлдэг гэсэн үндэслэлээр нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй гэдгийг УСНББОУСЗ цохон тэмдэглэсэн.

ДҮ19. Хамтын болон хувийн үйлчилгээний нягтлан бодох бүртгэлтэй холбоотой цаашдын асуудлууд. Эдгээр ажил гүйлгээний хувьд нөөцийг хүлээн зөвшөөрөх хэрэггүй гэсэн саналыг хүчтэй дэмждэг боловч хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь үүний шалтгаан үндэслэлийг улам хүчтэй болгох шаардлагатай гэж үзсэн. Эдгээр санал шүүмлэлийг харгалзан үзээд УСНББОУСЗ нь дараах дүгнэлтүүдийг гаргасан:

- (а) Хамтын болон хувийн үйлчилгээ нь улсын секторын байгууллагын байнгын тасралтгүй үйл ажиллагаа байхаас гадна УСНББОУС 19-ийн 27-р параграфт дурдсанчлан, байгууллагын ирээдүйн үйлдлээс хамааралгүй байдаг гэдгийг хариулт ирүүлсэн зарим хүмүүс дурдсан. Эдгээр хариулт ирүүлсэн хүмүүс нь уг тунхаглалын эцсийн хувилбарт үүнийг авч хэлэлцэх хэрэгтэй гэж үзсэн. Энэ нь зарим тохиолдолд үнэн байдаг гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн боловч олон улс орны хувьд хамтын үйлчилгээг үзүүлэх талаар засгийн газар болон улсын секторын бусад байгууллагад хууль ёсны шаардлага тавигддаг гэдгийг УСНББОУСЗ цохон тэмдэглэсэн. Үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар сонголт буюу өөрийн үзэмжийн асуудлууд байж болох хэдий ч үйлчилгээ үзүүлэх үүрэг хэвээр үлддэг. Иймээс УСНББОУСЗ нь энэ асуудлыг тусган оруулахгүй байхаар шийдвэрлэсэн.
- (б) Ирээдүйд үзүүлэх үйлчилгээний хувьд ирээдүйд төлөх татварыг хүлээн зөвшөөрөхгүйгээр тэрхүү үйлчилгээнд хамаарах томоохон өр төлбөрийг тухайн байгууллага хүлээн зөвшөөрөх нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахгүй, чанарын шинжүүдийг биелүүлэхгүй байх магадлалтай гэж зарим оролцогч талууд үзэж буйг УСНББОУСЗ мэдэгдсэн болохыг хариулт ирүүлсэн хүмүүс нь УСНББОУС 42-т цохон тэмдэглэсэн. Энэхүү шалтгаан үндэслэл нь хамтын болон хувийн үйлчилгээнд мөн адил хамаарна гэж тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс үзэж байсан. УСНББОУСЗ нь үүнтэй санал нэг байв.
- (в) Хамтын болон хувийн үйлчилгээг олон нийтэд үзүүлэх тухайн байгууллагын санаа зорилгоос нөөц үүсэхгүй боловч тэдгээр үйлчилгээг үзүүлэх заавал биелүүлэх хэлцлээс нөөц үүсгэж

ХАМТЫН БОЛОН ХУВИЙН ҮЙЛЧИЛГЭЭ (УСНББОУС 19-ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ)

болох юм гэдгийг хариулт ирүүлсэн зарим хүмүүс мэдэгдсэн. УСНББОУСЗ нь үүнтэй санал нэг байсан бөгөөд түүний үр нөлөөний талаар нэмэлт заавар удирдамж тусган оруулахыг зөвшөөрсөн.

- (г) СТ 67-д санал болгосон эрхийн бичгийн (ваучерын) бүртгэлийн хандлагын талаар эргэлзэж буйгаа хариулт ирүүлсэн зарим хүмүүс илэрхийлсэн бөгөөд агаарын тээврийн компанийн байнгын үйлчлүүлэгчийн хөтөлбөр гэх мэт үнэнч байдлын хөтөлбөртэй ижил арга замаар түүнийг тайлагнах эсэхийг тодруулж асуусан. Энэхүү эргэлзээтэй байдлыг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн бөгөөд тохиромжтой арга хандлага (өнгөрсөн үйл явдлын болон хүлээн зөвшөөрөлтийн цэгийн хувьд) нь тухайн эрхийн бичгийн (ваучерын) нөхцлөөс хамааран өөр өөр байна гэдгийг онцлон тэмдэглэсэн. УСНББОУСЗ нь эдгээр бүх нөхцөл байдлуудад хамаарах заавар удирдамж боловсруулах нь тохиромжгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Яаралтай тусламж

ДҮ20. УСНББОУСЗ нь яаралтай тусламжийн тайлагналын талаархи саналуудыг СТ 67-д тусган оруулсан. Хариулт ирүүлсэн олон хүмүүс нь ийм заавар удирдамжаар хангахыг дэмжиж байсан боловч хэд хэдэн асуудлуудыг дэвшүүлэн тавьсан. Улс орон бүр дэх янз бүрийн практикын улмаас яаралтай тусламжийн тодорхойлолт гаргахад төвөгтэй боловч ийм тодорхойлолт шаардлагатай гэж тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс үзэж байсан. Засгийн газрын байнгын тасралтгүй үйл ажиллагаа болох яаралтай тусламж ба тусгайлсан нэг яаралтай нөхцөл байдлын хариу болгон үзүүлэх яаралтай тусламжийг өөр хооронд нь ялган зааглах нь ямагт зохистой бөгөөд ийм санал болгосон ялган зааглалтыг тууштай мөрдөж болох эсэхийг тэдгээр хариулт ирүүлсэн хүмүүс бас сонирхож байв. Яаралтай тусламжийн цар хүрээнд хамаарахгүй бусад туслалцааг хэрхэн тайлагнах хэрэгтэй эсэхийг хариулт ирүүлсэн хүмүүс мөн асууж лавласан.

ДҮ21. Эдгээр нөхцөл байдлуудыг харгалзан үзээд УСНББОУСЗ нь СТ 67-д санал болгосон, яаралтай тусламжийн талаархи заавар удирдамжийг цаашид боловсруулахгүй байхаар шийдвэрлэсэн. УСНББОУСЗ нь өөрийн 2021 оны Дунд Хугацааны Ажлын Хөтөлбөрийн Зөвөлгөөг боловсруулахдаа уг сэдвийг харгалзан тусгахаар шийдвэрлэсэн байна.

...

НББОУС 37-ТОЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 19-ийг НББОУС 37 (1998)-гоос үндсэндээ бэлтгэсэн. УСНББОУС 19 ба НББОУС 37-гийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

...

- УСНББОУС 19 нь НББОУС 37-д ашигласан техникийн нэр томъёоны тодорхойлолт, түүнчлэн “бүрэн биелэгдээгүй гэрээ”-нд хамаарах нэмэлт тодорхойлолтыг агуулсан байдаг.
- УСНББОУС 19 нь хамтын болон хувийн үйлчилгээний талаархи нэмэлт заавар удирдамжаар хангадаг. Хамтын болон хувийн үйлчилгээний хувьд улсын секторын байгууллагууд нь нөөц хүлээн зөвшөөрдөггүй гэдгийг энд тайлбарласан.
- Улсын секторыг илүү сайн тусгахын тулд Хэрэгжүүлэх Заавар Удирдамжинд нэмэлт өөрчлөлт оруулсан.

...

УСНББОУС 42, *Нийгмийн Халамжийн Тэтгэмж*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

4А ба 35А параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур зурсан.

...

Цар хүрээ

...

4А. Хамтын болон хувийн үйлчилгээ нь (УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-д тодорхойлсончлон) нийгмийн халамжийн тэтгэмж биш юм. Эдгээр ажил гүйлгээний хувьд нөөц үүсгэх эсэхийг тодорхойлох заавар удирдамжийг УСНББОУС 19-д тусгасан.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

35А. Хамтын болон Хувийн Үйлчилгээ (УСНББОУС 19-ийн Нэмэлт өөрчлөлт)-ээр 4А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

ЗОХИОГЧИЙН ЭРХ, ХУДАЛДААНЫ ТЭМДЭГ, ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Саналын Төсөл, Зөвлөлдөх Баримт Бичиг, Санал Болгосон Практик Удирдамж болон УСНББОУСЗ-ийн бусад хэвлэлүүдийг ДНБХ-оос хэвлэн гаргасан бөгөөд түүний зохиогчийн эрхэд хамаарна.

Энэхүү хэвлэлд тусгагдсан материалуудад итгэл үзүүлэн үйлдэл хийсэн эсвэл үйлдлээ больсоны улмаас хэн нэгэнд хохирол учирсан тохиолдолд хохирол нь хайнга байдал буюу бусад шалтгаанаар үүссэн эсэхээс үл хамааран УСНББОУСЗ болон ДНБХ нь уг хохирлын хувьд хариуцлага хүлээхгүй болно.

‘International Public Sector Accounting Standards Board’ (Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл), ‘International Public Sector Accounting Standards’ (Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт), ‘Recommended Practice Guidelines’ (Санал Болгосон Практик Удирдамж), ‘International Federation of Accountants’ (Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо), ‘IPSASB’ (УСНББОУСЗ), ‘IPSAS’ (УСНББОУС), ‘RPG’ (СБПУ), ‘IFAC’ (ДНБХ), ‘IPSASB’ гэсэн лого, ‘IFAC’ гэсэн лого нь АНУ болон бусад улс орнууд дахь ДНБХ-ны худалдааны тэмдэг буюу бүртгэгдсэн худалдааны тэмдэг ба үйлчилгээний тэмдэг юм.

Зохиогчийн эрх © 2020 оны 01 дүгээр сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ). Бүх эрх хамгаалагдсан. Энэхүү баримт бичгийг хувиран олшруулах, хадгалах, шилжүүлэх буюу бусад адилтгах байдлаар ашиглахын тулд ДНБХ-ноос бичгэн зөвшөөрөл авах шаардлагатай. permission@ifac.org хаягаар хандана уу.

ДНБХ-ноос хэвлэв





**Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™**

529 тавдугаар өргөн чөлөө,
Нью Йорк, Нью Йорк 10017
Утас: + 1 (212) 286-9344
Факс: + 1 (212) 286-9570
www.ipsasb.org